



ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 7/243

Өмнөдэлгэр сум

Бог малын мялзан өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, аймгийн Засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/436 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад сумын хэмжээний бүх бог малыг бүрэн хамруулах ажлыг 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийг хүртэл 28 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.
2. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын вакцины хуваарь, дархлаажуулалтад хамрагдах малын тоог хавсралтаар баталсугай.
3. Малчдад урьдчилан мэдэгдэж, тарилгын хашаа, хоолой, ажиллах хүн хүчний бэлэн байдлыг хангаж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.
4. Дархлаажуулалтын ажлын хэсгийг мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, санхүүгийн болон бусад баримт материалыг бүрдүүлэн Мал эмнэлгийн газарт хүргүүлэхийг мал эмнэлгийн тасагт хариуцуулсугай.



Р.ЭНХТӨР



 сумын Засаг даргын 2025 оны

 07 дүгээр сарын 25-ны өдрийн

 А/245 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

БОГ МАЛЫН МЯЛЗАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

 ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	МЭҮН-ийн нэр	Дархлаажуулах малын тоо					Шаардлагагай вакцин	
		Хонь	Ямаа	Хурга	Ишиг	Нийт	Шингэлэгч /мл/	Вакцин
1	Юмт гэгээ	112379	97100	67686	49035	326200	326200	326200
2	Хичээнгүй экспресс	39419	32091	23885	16205	111600	111600	111600
3	Мэргэн жонон	37691	25304	22827	12778	98600	98600	98600
4	Хэйлти анимал стронг	33084	23945	19879	12092	89000	89000	89000
5	Өвөр зотлог	15394	12511	9214	6481	43600	43600	43600
Сумын дүн		237967	190951	143491	96591	669000	669000	669000